



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Эрдэнэцогт сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/10/СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

(Хотын нэр оруулах)

2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг:

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг:

Аудитор: Ш.Даваабат

Утас: Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	4
2.1.	Оршил	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар.....	8
2.8.2	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар	8
2.8.2.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13.	Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:.....	9
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12

1 Аудитын гэрчилгээ

Батлагдсан гэрчилгээ скайннердаж энд оруулах

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Эрдэнэцогт сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Сумын Засаг дарга Ц.Төмөрбаатард танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2,3-д заасны дагуу Эрдэнэцогт сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэцогт сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.03.15-наас 2019.03.18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.03.18-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын гэрээт аудитор Ш.Даваабат хариуцаж хэрэгжүүлэв.

Эрдэнэцогт сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 1/39 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Эрдэнэцогт сумын Засаг даргын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Эрдэнэцогт сумын Засаг дарга нь “Бид эрүүл чийрэг хөгжсөн иргэнтэй, эрчимжсэн хөдөө аж ахуй, байгальд ээлтэй дэд бүтэц, үйлдвэрлэл үйлчилгээ, аялал жуулчлалыг цогцоор нь хөгжүүлсэн бүсийн төв, улсын тэргүүний сум болох” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Эрдэнэцогт сумын Засаг дарга удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 8 байгууллага, нэгж 2018 оны санхүүгийн тайландаа аудит хийж баталгаажуулахаас 8 байгууллага аудитад хамрагдсан байна.

Төрийн аудитын байгууллагаас Эрдэнэцогт сумын Засаг дарга эрх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр						
№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Түүвэрлэсэн	Итгэл үзүүлсэн	Гэрээгээр хийлгэсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	4	3		1	
2	ТБӨӨААН					
	Дүн	4	3		1	

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Эрдэнэцогт сумын Засаг даргын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эрдэнэцогт сумын Засаг дарга санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Эрдэнэцогт сумын Засаг дарга санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Санхүүгийн тооцоолох ХХК-нийн "Aclous" программ хангамж ашигладаг байна.

Эрдэнэцогт сумын Засаг даргын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

Эрдэнэцогт сумын Засаг даргын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 оны 11 дүгээр сард хийсэн аудитаар зөрчил дутагдал илрээгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Эрдэнэцогт сумын Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс 2,0 хувиар сонгов.

Үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь санхүүгийн тайланг аккурэль сууриар бэлтгэсэнтэй холбоотой юм.

Эрдэнэцогт сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн зардлын дүн 2052968,5 мянган төгрөг бөгөөд түүний 2,0 хувь болох 44746,67 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн материаллаг биш боловч цаашид санхүүгийн тайлан, тодруулгад материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй зарим асуудлыг толилуулж байна.

Эрдэнэцогт сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 22852.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, 19100,0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 374,8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, дахин давтахгүй байх зөвлөмж, 3377,3 мянган төгрөгийн залруулага хийсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд алдаа, зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлыг хэрхэн ангилж, шийдвэрлэсэн байдлыг энэ тайлангийн 2.13-т нэгтгэсэн байдлаар үзүүлэв.

Асуудлыг өмнөх түвшинд хийсэн аудитын явцад гарсан асуудал, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад түүвэрт хамрагдсан асуудлаас илэрсэн асуудал гэсэн ангиллаар үзүүлэв. Үүнд:

2.8.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

Асуудал 1: Ерөнхий боловсролын сургууль ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 374773 төгрөгийг хоол хүнсний зардлаас төсвийн зохицуулалт хийлгүйгээр зарцуулсан байна.

Шийдэл: Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

Асуудал 2: СХС-аас зээл авсан иргэдийн авлага, өглөгийг судалгаа болон мөнгөн хөрөнгийн журналаас тулган шалгахад 67,0 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлээс 48,3 сая төгрөгийг төлүүлэхээр шүүхэд хандсан 19,1 сая төгрөгийн зээлийг төлүүлэх арга хэмжээ аваагүй байна.

Шийдэл: Төлбөрийн акт тогтоосон.

Асуудал 3: ИТХ-ийн Алба хаагчдад олгох татварын хөнгөлөлтийн зөрүү 163.0 мянган төгрөгний өглөг, татварт илүү шилжүүлсэн 96.9 мянган төгрөгийн авлагыг дутуу, тусгасан байна.

Асуудал 4: Аудитаар ЗДТГазрын нягтлан бодогч ХХОАТ-ыг буруу тооцож авснаас ажиллагсдаас илүү суутган 446.6 мянган төгрөгийн авлага, хүмүүст төлөх өглөг үүссэн, байхад тайланд авлагыг 35.1 мянган төгрөгөөр дутуу өглөгийг тусгаагүй. Мөн НДШ төлөлтийн тайлангаар 35.7 мянган төгрөгийн авлагатай гарсан байхад тайланд тусгаагүй байна.

Асуудал 5: Сумын Засаг даргын захирамжаар сумын ЗДТГ, Соёлын төв, ЕБС-ийн барилгын инженер геологийн судалгааны ажлыг Ганхошуу ХХК-иар хийлгэн ажлын хөлсний урьдчилгаа төлбөрт 2.6 сая төгрөг олгосныг ОНХС-гийн тайланд авлагаар тусгаагүй байна.

Шийдэл: 3, 4, 5 алдааг тус тус залруулсан

2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд алдаа, зөрчил илрээгүй болно.

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад алдаа, зөрчил илрээгүй болно.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Эрдэнэцогт сумын Засаг дарга чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 1873642,8 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн орлогын нийт гүйцэтгэл 1814277,9 мянган төгрөг буюу 96,8 хувь, зардлын нийт гүйцэтгэл 1758518,1 мянган төгрөг буюу 93,8 хувьтай байгаа нь төсөвт байгууллагууд 570,8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн, СХС-гаас олгох зээлийг 98541,9 мян/төгрөгөөр баталж 36177,2 мян/төгрөгийг зарцуулсан, ОНХС-гийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлын санхүүжилтэд 91858,0 мян/төгрөгийг олгохоос 28086,7 мян/төгрөгийг зарцуулсантай тус тус холбоотой байна.

Төсвийн орлого, зардлын төлөвлөгөөний биелэлтийг харьяа байгууллагаар нь авч үзвэл төсөвт байгууллагын өөрийн орлогоор 3100,0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээс 2723,5 мянган төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 376,5 мянган төгрөгөөр тасарсан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Эрдэнэцогт сумын Засаг дарга Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100,0 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Эрдэнэцогт сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар алдаа зөрчил илрээгүй. Харин эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 22852,1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил түүний шийдвэрлэлийн байдлыг дор нэгтгэн үзүүлэв. Үүнд:

(Мянган төгрөг)

№	Байгууллагын ангилал	Илрүүлэлт						Залруулга	
		Зөрчил		Алдаа		Бүгд дүн		Тоо	Дүн
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	ТТЗ								
2	ТШЗ	2	19474,8	3	3377,3	5	22852,1	3	3377,3
3	ТБОӨААН								
	Дүн	2	19474,8	3	3377,3	5	22852,1	3	3377,3

Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

(Мянган төгрөг)

Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2	ТШЗ	2	19474,8	1	19100			1	374,8				
3	ТБОӨААН												
	Дүн	2	19474,8	1	19100			1	374,8				

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрдэнэцогт сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эрдэнэцогт сумын Засаг даргын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв

Санал дүгнэлтийн хэлбэр (Тоогоор)

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан				Дүн
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	
1	ТШЗ	5			5	
2	ТБӨААН					
	Дүн	5			5	

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>564,909,696.9</u>	<u>526,857,127.2</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	189,021,898.2	154,528,306.6
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	189,021,898.2	154,528,306.6
3121	Төгрөг	189,021,898.2	154,528,306.6
31211	Төрийн сангийн харилцах	189,021,898.2	154,528,306.6
33	АВЛАГА	137,957,465.8	135,732,902.0
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	300,000.0	2,400,803.0
335	Бусад авлага	7,421,639.8	3,630,319.0
3351	Байгууллагаас авах авлага	2,975,739.8	3,630,319.0
3352	Хувь хүмүүсээс авах авлага	4,445,900.0	
336	Зээлийн авлага	130,235,826.0	129,701,780.0
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн ав	130,235,826.0	129,701,780.0
33612	Хувь хүмүүст олгосон зээл	130,235,826.0	129,701,780.0
35	БАРАА МАТЕРИАЛ	237,930,332.9	236,595,918.7
351	Түүхий эд материал	33,905,225.0	30,662,849.0
35110	Тусгай зориулалттай материал	29,884,042.0	30,394,649.0
35130	Эм боох материал	4,021,183.0	268,200.0
354	Хангамжийн материал	164,562,607.9	192,842,569.7
35410	Бичиг хэргийн материал	2,814,840.0	3,674,700.0
35420	Аж ахуйн материал	153,335,110.5	180,446,521.3
35440	Түлш, шатах тослох материал	1,342,214.0	
35460	Хүнсний материал	4,225,593.4	6,248,848.4
35470	Бусад хангамжийн материал	2,844,850.0	2,472,500.0
35600	Мал амьтад	39,462,500.0	13,090,500.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,103,359,138.0</u>	<u>4,269,454,862.7</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,103,359,138.0	4,269,454,862.7
392	Биет хөрөнгө	3,102,785,388.2	4,181,597,613.0
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,020,639,262.1	4,132,380,668.4
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,388,624,169.8)	(353,911,546.8)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	220,023,150.0	183,679,234.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	(82,960,120.9)	(75,968,579.0)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	611,651,896.0	530,533,923.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	(381,591,090.9)	(367,966,971.9)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	171,243,234.0	215,039,134.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	(98,807,657.2)	(114,399,133.6)
39217	Ном	31,210,884.9	32,210,884.9

Эрдэнэцогт сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

393	Биет бус хөрөнгө	573,749.7	87,857,249.7
39301	Програм хангамж	1,780,000.0	1,780,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,206,250.3)	(1,280,750.3)
39303	Бусад биет бус хөрөнгө		87,358,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,668,268,834.8</u>	<u>4,796,311,989.9</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>552,184.0</u>	<u>3,595,778.6</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	552,184.0	3,595,778.6
41225	Бусад гадаад эх үүсвэрээс		
413	Өглөг	552,184.0	3,595,778.6
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	354,384.0	3,179,062.6
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	197,800.0	197,800.0
4136	Бусад өглөг	-	218,916.0
41361	Байгууллагад төлөх өглөг		187,000.0
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		31,916.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,667,716,650.8</u>	<u>4,792,716,211.4</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,667,716,650.8	4,792,716,211.4
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,501,408,540.7	1,588,966,540.7
51101	Өмч: - төрийн	1,501,408,540.7	1,588,966,540.7
512	Хуримтлагдсан үр дүн	1,303,280,671.5	1,021,984,989.9
51210	Өмнөх үеийн үр дүн	1,006,656,208.6	1,303,280,671.5
51220	Тайланг үеийн үр дүн	296,624,462.9	(281,295,681.6)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	863,027,438.7	2,181,764,680.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,668,268,834.8</u>	<u>4,796,311,989.9</u>

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,615,889,501.0	1,956,037,891.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	40,851,113.0	15,448,847.8
110	Орлогын албан татвар	11,815,224.0	6,884,910.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	4,650,000.0	6,884,910.8
110002	Үйл ажиллагааны орлого		6,884,910.8
110004	Хөрөнгө борлуулсны орлого	4,650,000.0	
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	7,165,224.0	-
110201	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар	7,165,224.0	
113	Хөрөнгийн албан татвар	3,510,000.0	4,080,000.0
113002	Бууны албан татвар	3,510,000.0	4,080,000.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	25,525,889.0	4,483,937.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,619,400.0	4,143,600.0
118001	Улсын тэмдэгтийн хураамж	3,319,400.0	2,643,600.0
118006	Түгээмэл тархацгай ашигт малтмал ашигласны төлбөр	300,000.0	1,500,000.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	21,596,489.0	-
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	2,246,740.0	
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	19,200,000.0	
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	149,749.0	
1183	Бусад татвар	310,000.0	340,337.0
118301	Бусад татвар		40,337.0
118304	Нохойны албан татвар	310,000.0	300,000.0

Эрдэнэцогт сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	204,916,522.0	115,481,263.6
120	Нийтлэг татварын бус орлого	117,416,522.0	115,481,263.6
120002	Хүүгийн орлого	3,860,981.0	13,081,598.6
120003	Торгуулийн орлого	1,535,300.0	423,170.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	112,020,241.0	101,976,495.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	88,013,442.0	2,929,753.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,730,094.0	32,425,500.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	19,276,705.0	66,621,242.0
121	Хөрөнгийн орлого	87,500,000.0	-
121002	Өмч хувьчлалын орлого	87,500,000.0	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,370,121,866.0	1,825,107,780.3
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,343,082,771.0	1,335,630,303.0
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,998,171.0	570,803.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,341,084,600.0	1,335,059,500.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,426,278.0	93,132,648.3
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,426,278.0	93,132,648.3
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	639,429,000.0	376,741,800.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	334,872,100.0	-
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	6,307,000.0	
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	286,508,100.0	324,883,800.0
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	11,741,800.0	51,858,000.0
1330	Төсвийн захирагчдаас	332,185,941.0	-
133003	Хөрөнгийн	332,185,941.0	
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	35,997,876.0	19,603,029.0
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	35,997,876.0	19,603,029.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,319,265,039.1	2,052,968,512.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,274,210,479.1	2,027,481,712.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,763,702,601.1	1,798,718,622.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	973,438,021.0	1,016,359,925.0
210101	Үндсэн цалин	961,700,875.0	1,016,359,925.0
210102	Нэмэгдэл	5,009,141.0	
210104	Урамшуулал	6,728,005.0	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,458,380.2	121,659,486.3
210201	Тэтгэврийн даатгал	106,458,380.2	121,659,486.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	221,651,923.0	227,773,592.0
210301	Гэрэл, цахилгаан	13,100,078.0	15,588,967.0
210302	Түлш, халаалт	207,734,045.0	211,798,225.0
210303	Цэвэр, бохир ус	817,800.0	386,400.0
2104	Хангамж, бараа материалын зардал	46,398,685.0	62,643,823.2
210401	Бичиг хэрэг	11,240,607.0	8,721,236.0
210402	Тээвэр, шатахуун	25,971,659.0	38,307,950.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,192,319.0	7,026,176.0
210404	Ном, хэвлэл	53,900.0	84,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариу	843,000.0	1,032,200.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,097,200.0	4,564,861.2
210408	Бараа материал акталсны зардал		2,907,400.0

Эрдэнэцогт сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2105	Нормативт зардал	100,958,069.6	140,684,201.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,167,372.0	27,215,666.0
210502	Хоол, хүнс	83,240,427.6	112,681,455.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,550,270.0	787,080.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,670,680.0	5,473,500.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	21,000.0	
210604	Урсгал засвар	17,649,680.0	5,473,500.0
2107	Томилолт, зочны зардал	10,819,400.0	8,686,700.0
210702	Дотоод албан томилолт	10,819,400.0	8,686,700.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	7,972,174.0	29,816,155.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлгэг ажил үйлчилгээ	7,010,274.0	29,570,955.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232,500.0	200,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	551,400.0	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	58,000.0	
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.0	
210807	Газрын төлбөр	90,000.0	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		45,200.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	278,335,268.3	185,621,240.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	111,571,144.0	23,216,562.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,165,000.0	4,264,100.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	165,599,124.3	158,140,578.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	510,507,878.0	228,763,089.3
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	6,500,000.0
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		6,500,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	169,338,359.0	134,072,577.0
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	35,997,876.0	19,682,529.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	35,082,199.0	9,073,200.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	43,775,924.0	21,276,400.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан алба	24,810,150.0	47,495,608.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29,672,210.0	36,544,840.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,257,432.0	87,500,000.3
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,257,432.0	87,500,000.3
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олг	336,870,271.0	570,803.0
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллал	334,872,100.0	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,998,171.0	570,803.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	41,816.0	119,709.0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	41,816.0	119,709.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	45,054,560.0	25,486,800.0
2200	Дотоод эх үүсвэрээр	45,054,560.0	25,486,800.0
220001	Барилга байгууламж	45,054,560.0	25,486,800.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	296,624,461.9	(96,930,620.3)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	184,365,061.3
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		110,349,375.1
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал		74,015,686.2
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(184,365,061.3)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	296,624,461.9	(281,295,681.6)

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,258,119,856.0</u>	<u>1,924,950,695.7</u>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	128,351,114.0	28,530,446.4
110	Орлогын албан татвар	99,315,224.0	19,966,509.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	99,315,224.0	19,966,509.4
110002	Үйл ажиллагааны орлого	7,165,224.0	6,884,910.8
110003	Хөрөнгийн орлого	87,500,000.0	13,081,598.6
110004	Хөрөнгө борлуулсны орлого	4,650,000.0	
113	Хөрөнгийн албан татвар	3,510,000.0	4,080,000.0
113002	Бууны албан татвар	3,510,000.0	4,080,000.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	25,525,890.0	4,483,937.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,619,400.0	4,143,600.0
118001	Улсын тэмдэгтийн хураамж	3,319,400.0	2,643,600.0
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	300,000.0	1,500,000.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	21,596,490.0	-
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	2,246,740.0	
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	19,200,000.0	
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	149,750.0	
1183	Бусад татвар	310,000.0	340,337.0
118301	Бусад татвар		40,337.0
118304	Нохойны албан татвар	310,000.0	300,000.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	98,139,817.0	71,312,469.0
120	Нийтлэг татварын бус орлого	98,139,817.0	71,312,469.0
120002	Хүүгийн орлого	3,860,981.0	
120003	Торгуулийн орлого	1,535,300.0	423,170.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	92,743,536.0	70,889,299.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос	87,528,442.0	38,463,799.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос	5,215,094.0	32,425,500.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,031,628,925.0	1,825,107,780.3
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,343,082,771.0	1,335,630,303.0
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,998,171.0	570,803.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс	1,341,084,600.0	1,335,059,500.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,426,278.0	93,132,648.3
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт	19,426,278.0	93,132,648.3
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	633,122,000.0	376,741,800.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	334,872,100.0	-
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	286,508,100.0	324,883,800.0
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	11,741,800.0	51,858,000.0
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	35,997,876.0	19,603,029.0
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	35,997,876.0	19,603,029.0

Эрдэнэцогт сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,051,336,398.0	1,889,824,487.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,051,336,398.0	1,889,824,487.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,536,606,450.0	1,626,761,724.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	978,106,902.0	1,003,322,023.0
210101	Үндсэн цалин	874,317,828.0	811,977,623.0
210102	Нэмэгдэл	66,781,467.0	134,349,900.0
210104	Урамшуулал	37,007,607.0	49,794,500.0
210105	Гэрээт ажлын хөлс		7,200,000.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	103,189,308.0	120,638,872.0
210201	Тэтгэврийн даатгал	103,189,308.0	82,134,943.0
210202	Тэтгэмжийн даатгал		9,771,885.0
210203	ҮОМШӨ-ний даатгал		7,786,099.0
210204	Ажилгүйдлийн даатгал		1,957,497.0
210205	Эрүүл мэндийн даатгал		18,988,448.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	222,534,688.0	226,229,598.0
210301	Гэрэл, цахилгаан	11,526,607.0	13,697,347.0
210302	Түлш, халаалт	209,706,281.0	212,188,251.0
210303	Цэвэр, бохир ус	1,301,800.0	344,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	40,312,401.0	51,036,139.0
210401	Бичиг хэрэг	4,476,272.0	5,680,612.0
210402	Тээвэр, шатахуун	25,722,916.0	33,877,219.0
210403	Шуудан, холбоо, ингернэгийн төлбөр	5,591,763.0	4,575,308.0
210404	Ном, хэвлэл	553,100.0	606,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хоргон мэрэгчдийн устгал, ариутгал	1,607,500.0	1,397,600.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,360,850.0	4,899,400.0
2105	Нормативт зардал	111,059,033.0	103,419,713.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,544,491.0	18,621,900.0
210502	Хоол, хүнс	80,715,069.0	80,820,383.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,799,473.0	3,977,430.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,041,822.0	13,077,600.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,861,100.0	4,154,100.0
210602	Тавилга		1,840,000.0
210604	Урсгал засвар	11,180,722.0	7,083,500.0
2107	Томилолт, зочны зардал	10,838,109.0	7,892,200.0
210701	Гадаад албан томилолт	1,800,000.0	
210702	Дотоод албан томилолт	9,038,109.0	7,892,200.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,528,081.0	57,577,287.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,566,181.0	54,846,279.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232,500.0	
210803	Даатгалын үйлчилгээ	399,700.0	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	209,700.0	
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.0	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		2,604,000.0
210807	Газрын төлбөр	90,000.0	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		127,008.0

Эрдэнэцогт сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,996,106.0	43,568,292.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,247,271.0	35,943,482.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,748,835.0	7,624,810.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	514,729,948.0	263,062,763.3
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	30,672,000.0
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		30,672,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	173,560,429.0	144,200,251.0
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	35,997,876.0	19,603,029.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	39,304,269.0	17,507,190.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	43,775,924.0	21,276,400.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	24,810,150.0	79,230,448.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29,672,210.0	6,583,184.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,257,432.0	87,500,000.3
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,257,432.0	87,500,000.3
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	336,870,271.0	570,803.0
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	334,872,100.0	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,998,171.0	570,803.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	41,816.0	119,709.0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	41,816.0	119,709.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	206,783,458.0	35,126,208.4
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	60,939,160.0	69,619,800.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	60,939,160.0	69,619,800.0
2200	Дотоод эх үүсвэрээр	60,939,160.0	69,619,800.0
223001	Бусад хөрөнгө	45,054,560.0	28,086,800.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,884,600.0	41,533,000.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(60,939,160.0)	(69,619,800.0)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	58,500,000.0	-
230001	Эргэж төлөгдөх зээл	58,500,000.0	
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(58,500,000.0)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	87,344,298.0	(34,493,591.6)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	101,677,600.2	189,021,898.2
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	189,021,898.2	154,528,306.6

3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,501,408,540.7	863,027,438.7	1,006,656,208.6	3,371,092,188.0
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,501,408,540.7	863,027,438.7	1,006,656,208.6	3,371,092,188.0
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
C07	Тайланг үеийн үр дүн			296,624,462.9	296,624,462.9
C08	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,501,408,540.7	863,027,438.7	1,303,280,671.5	3,667,716,650.8
D01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,501,408,540.7	863,027,438.7	1,303,280,671.5	3,667,716,650.8
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,501,408,540.7	863,027,438.7	1,303,280,671.5	3,667,716,650.8
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		1,318,737,242.1		1,318,737,242.1
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	87,558,000.0			87,558,000.0
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайланг үеийн үр дүн			(281,295,681.6)	(281,295,681.6)
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,588,966,540.7	2,181,764,680.8	1,021,984,989.9	4,792,716,211.4

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,829,714,400.0	1,773,975,607.0	1,873,642,800.0	1,758,518,098.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,677,848,800.0	1,670,421,047.0	1,781,784,800.0	1,730,431,298.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,538,928,000.0	1,532,858,538.0	1,662,489,000.0	1,611,162,916.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	975,449,400.0	978,106,902.0	1,004,181,300.0	1,003,322,023.0
210101	Үндсэн цалин	869,916,700.0	874,317,828.0	812,836,900.0	811,977,623.0
210102	Нэмэгдэл	66,829,900.0	66,781,467.0	134,349,900.0	134,349,900.0
210104	Урамшуулал	38,702,800.0	37,007,607.0	49,794,500.0	49,794,500.0
210105	Гэрээт ажлын хөлс			7,200,000.0	7,200,000.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шим	106,810,800.0	103,189,308.0	120,639,600.0	120,638,872.0
210201	Тэтгэврийн даатгал	67,716,600.0	103,189,308.0	81,591,900.0	82,134,943.0
210202	Тэтгэмжийн даатгал	7,895,700.0		9,771,300.0	9,771,885.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,696,700.0		7,785,600.0	7,786,099.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,954,700.0		1,958,300.0	1,957,497.0
210205	Эрүүл мэндийн даатгал	19,547,100.0		19,532,500.0	18,988,448.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	223,032,100.0	222,534,688.0	226,229,700.0	226,229,598.0
210301	Гэрэл, цахилгаан	11,831,300.0	11,526,607.0	13,697,400.0	13,697,347.0
210302	Түлш, халаалт	210,356,600.0	209,706,281.0	212,188,300.0	212,188,251.0
210303	Цэвэр, бохир ус	844,200.0	1,301,800.0	344,000.0	344,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	40,315,900.0	40,605,201.0	51,109,200.0	51,036,139.0
210401	Бичиг хэрэг	4,489,400.0	4,476,272.0	5,732,200.0	5,680,612.0
210402	Тэвэр, шатахуун	25,356,400.0	25,722,916.0	33,897,800.0	33,877,219.0
210403	Шуудан, холбоо, ингэрнэгийн төлбөр	5,616,200.0	5,591,763.0	4,576,200.0	4,575,308.0
210404	Ном, хэвлэл	840,400.0	845,900.0	606,000.0	606,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устга	1,628,900.0	1,607,500.0	1,397,600.0	1,397,600.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,384,600.0	2,360,850.0	4,899,400.0	4,899,400.0
2105	Нормативт зардал	113,049,800.0	112,979,033.0	103,439,100.0	103,419,713.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,545,300.0	16,544,491.0	18,625,500.0	18,621,900.0
210502	Хоол, хүнс	80,781,600.0	80,715,069.0	80,835,200.0	80,820,383.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	15,722,900.0	15,719,473.0	3,978,400.0	3,977,430.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,918,600.0	22,951,822.0	18,088,200.0	18,077,600.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,784,500.0	9,861,100.0	9,154,100.0	9,154,100.0
210602	Тавилга			1,850,000.0	1,840,000.0
210604	Урсгал засвар	13,134,100.0	13,090,722.0	7,084,100.0	7,083,500.0

Эрдэнэцогт сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2107	Томилолт, зочны зардал	11,040,700.0	10,838,109.0	8,158,000.0	7,892,200.0
210701	Гадаад албан томилолт	1,800,000.0	1,800,000.0		
210702	Дотоод албан томилолт	9,240,700.0	9,038,109.0	8,158,000.0	7,892,200.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,073,800.0	5,662,279.0	92,375,300.0	42,254,287.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,945,600.0	4,700,379.0	89,630,800.0	39,523,279.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.0	232,500.0	-	-
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.0	399,700.0	-	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	209,700.0	209,700.0	-	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.0	30,000.0	-	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ			2,604,000.0	2,604,000.0
210807	Газрын төлбөр	90,000.0	90,000.0	-	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	148,500.0		140,500.0	127,008.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,236,900.0	35,991,196.0	38,268,600.0	38,292,484.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,486,100.0	34,242,361.0	30,640,400.0	30,667,674.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,750,800.0	1,748,835.0	7,628,200.0	7,624,810.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	138,920,800.0	137,562,509.0	119,295,800.0	119,268,382.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-	30,672,100.0	30,672,000.0
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг			30,672,100.0	30,672,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	138,920,800.0	137,562,509.0	88,623,700.0	88,596,382.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	39,305,700.0	39,304,225.0	17,508,000.0	17,507,190.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	43,780,900.0	43,775,924.0	21,276,400.0	21,276,400.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	24,810,200.0	24,810,150.0	43,255,600.0	43,229,608.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	31,024,000.0	29,672,210.0	6,583,700.0	6,583,184.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	86,705,300.0	45,054,560.0	91,858,000.0	28,086,800.0
2200	Дотоод эх үүсвэрээр	86,705,300.0	45,054,560.0	91,858,000.0	28,086,800.0
223001	Бусад хөрөнгө	86,705,300.0	45,054,560.0	91,858,000.0	28,086,800.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	65,160,300.0	58,500,000.0	-	-
230001	Эргэж төлөгдөх зээл	65,160,300.0	58,500,000.0		
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,831,414,400.0	1,773,938,339.0	1,873,642,800.0	1,814,277,887.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,341,084,500.0	1,336,827,168.0	1,335,059,500.0	1,334,939,791.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,341,084,500.0	1,336,827,168.0	1,335,059,500.0	1,334,939,791.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	337,918,300.0	344,615,729.0	402,441,700.0	408,448,797.0
132001	Орон нутгийн төсвөөс	326,176,500.0	332,873,929.0	350,583,700.0	356,590,797.0
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	11,741,800.0	11,741,800.0	51,858,000.0	51,858,000.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	152,411,600.0	92,495,442.0	136,141,600.0	70,889,299.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	67,360,300.0	87,545,942.0	38,963,800.0	38,463,799.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,664,500.0	4,949,500.0	600,000.0	32,425,500.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	78,386,800.0		96,577,800.0	-
4	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл		92,389,756.2	-	92,352,488.2
5	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		92,352,488.2	-	148,112,277.2
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	6.0	6.0	6.0	6.0
610001	Төсвийн байгууллага	6.0	6.0	6.0	6.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	114.0	114.0	112.0	112.0
620001	Удирдах ажилтан	14.0	14.0	14.0	14.0
620002	Гүйцэтгэх ажилтан	72.0	72.0	64.0	64.0
620003	Үйлчлэх ажилтан	27.0	27.0	31.0	31.0
620004	Гэрээт ажилтан	1.0	1.0	3.0	3.0

Эрдэнэцогт сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	597.0	597.0	513.0	513.0
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	497.0	497.0	413.0	413.0
630001	Төрийн өмчит ЕБС	497.0	497.0	413.0	413.0
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	100.0	100.0	100.0	100.0
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	100.0	100.0	100.0	100.0
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	1,728.0	1,728.0	-	2,234.0
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо	248.0	248.0		234.0
640002	Улсын эмнэлгийн амбулатороор эмчлүүлэгсдийн тоо	1,480.0	1,480.0		2,000.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	112.0	113.0	112.0	112.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9.0	10.0	9.0	9.0
650004	ССБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	45.0	45.0	45.0	45.0
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	5.0	5.0	5.0	5.0
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	18.0	18.0	18.0	18.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	23.0	23.0	23.0	23.0
650010	Гэрээт ажилтан	3.0	3.0	3.0	3.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	9.0	9.0	9.0	9.0